



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

**Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт
шалгалтын ажлыг зохион байгуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хангах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, алба хаагчдын цэргийн үүргийн биелэлтэд хяналт шалгалтыг хуваарийн дагуу 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Цэргийн үүргийн биелэлтэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хамрагдах байгууллагын жагсаалтыг хоёрдугаар, удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар байгууллагуудтай хамтран ажиллаж, хяналт шалгалт явуулсан тухай тайлан, мэдээг нэгтгэн 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (дэд хурандаа Г.Нямхүү)-т үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 1 сарын 16-ны өдрийн
1708 дугаар захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:

Г.Нямхүү

Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын
дарга, дэд хурандаа

Гишүүд:

Б.Сайнбуян


Засаг даргын Тамгын газрын Цэргийн
штабын Тоо бүртгэлийн ахлах офицер, дэд
хурандаа

Нарийн бичгийн дарга:

С.Алтан-Очир

Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын
Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл,
сургалтын офицер, хошууч


Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 сарын 16-ны өдрийн
108 дугаар захирамжийн хавсралт



ЦЭРГИЙН ҮҮРЭГТНИЙ ҮЗЛЭГ, БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТАД ХАМРАГДАХ АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Хугацаа	Байршил	Тайлбар
1.	УБТЗ-ын Багахангай өртөө	2-р сарын 13-ны өдөр	БХД-ийн 2-р хороо	
2.	УБТЗ-ын Холбооны хэсэг	3-р сарын 24-ны өдөр	БХД-ийн 2-р хороо	
3.	Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж	3-р сарын 25-ны өдөр	БХД-ийн 1-р хороо	
4.	Хангай Ган-Эрдэнэ ХХК	4-р сарын 09-ны өдөр	БХД-ийн 1-р хороо	
5.	Багахангайн үйлдвэрлэл технологийн парк	4-р сарын 10-ны өдөр	БХД-ийн 1-р хороо	
6.	Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны 1971-2000 оны алба хаагаагүй иргэд	1,2,3,4,5,6-р саруудад	БХД-ийн 1-р хороо	
7.	Багахангай дүүргийн 2 дугаар хорооны 1971-2000 оны алба хаагаагүй иргэд	1,2,3,4,5,6-р саруудад	БХД-ийн 2-р хороо	

Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 01 сарын 16-ны өдрийн
01/08 дугаар захирамжийн хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮҮРГИЙН
ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Шалгалтын зорилго

1.1. Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөөний дагуу дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа зарим байгууллага, аж ахуйн нэгжүүдэд Батлан хамгаалах багц хуулиуд, Дайчилгааны тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гарсан тогтоол, журам, зааврын хэрэгжилтийн байдалтай танилцаж, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хоёр. Шалгалт хийх эрх зүйн үндэслэл

2.1. Монгол Улсын “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5.6, 5.10, МУ-ын Батлан хамгаалах тухай хуулийн 18.1, 19.1, Төрийн албаны тухай хуулийн 22.1.7, Цэргийн албаны тухай хуулийн 4, 12, 29, 34 дүгээр зүйлүүдэд заагдсан эрх хэмжээний хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулна.

Гурав. Хамрагдах байгууллага, аж ахуйн нэгжүүд

- 3.1. УБТЗ-ын Багахангай өртөө
- 3.2. УБТЗ-ын Холбооны хэсэг
- 3.3. Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж
- 3.4. Хангай Ган-Эрдэнэ ХХК
- 3.5. Багахангайн үйлдвэрлэл технологийн парк
- 3.6. Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны 1971-2000 оны алба хаагаагүй иргэд
- 3.7. Багахангай дүүргийн 2 дугаар хорооны 1971-2000 оны алба хаагаагүй иргэд

Дөрөв. Шалгалтын чиглэл

4.1. Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар байгууллагын удирдлагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй танилцах.

- 4.1.1. 1971 оноос хойш төрсөн эрчүүдийн цэргийн алба хаасан байдал;
- 4.1.2. 18-25 насны эрчүүд цэргийн жинхэнэ албаны татлагад хамрагдсан байдал;

- 4.1.3. Цэргийн бүртгэлд хамрагдсан байдал;
- 4.1.4. Мөнгөн төлбөр төлөх иргэдийг тогтоож, төлбөрийг төлүүлэх;
- 4.1.5. Цэргийн үүрэгтний үнэмлэхэд үзлэг, нөхөн олголт хийх.

Тав. Байгууллага аж ахуйн нэгжээс бүрдүүлж авах баримт бичиг

- 5.1. Байгууллагын товч танилцуулга;
- 5.2. 18-50 насны иргэдийн судалгааг доорх маягтаар ирүүлэх; /1971-2000-он/

18-50 насны эрчүүдийн цэргийн үүрэгтний биелэлтийн судалгаа

№	Овог нэр	Регистр	Нас	ЦҮ-ний үнэмлэхний дугаар	Цэргийн албыг аль нэг хэлбэрээр хаасан байдал	Цэргийн бүртгэл д орсон байдал	Албан тушаал	Гэрийн хаяг, утасны дугаар	Тайлбар

5.3.Цэргийн жинхэнэ болон дүйцүүлэх албыг хаагаагүй 26 нас хүрсэн цэргийн бэлтгэл үүрэгтэн их, дээд сургууль төгссөн дипломыг хуулбарлан баталгаажуулсан байх;

5.4.Судалгаанд хамрагдсан эрчүүдийн цэргийн үүрэгтний үнэмлэхийг хураан авч бэлтгэсэн байх;

5.5.Шалгагчийг хүн нэг бүртэй уулзуулах боломжоор хангах ба төгсгөлд нь 2% акт үйлдэн дарга (захирал) гарын үсэг зурж баталгаажуулна.

Зургаа. Шалгалт хийх бүрэлдэхүүн, хугацаа, дүнгийн талаар

6.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас томилогдсон ажлын хэсэг шалгалтыг явуулна.

6.2. Шалгалтыг нэг байгууллагад ажлын 1-2 өдөрт багтаан явуулна.

6.3. Шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан байгууллагын удирдлагад танилцуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч цаашид анхаарч ажиллах чиглэлийн талаар зөвлөгөө өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

6.4. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт явуулсан дүнг 2025 оны 06 дугаар сарын 30-ны дотор ажлын хэсгийн ахлагч дүүргийн Засаг даргад танилцуулна.